# УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛГИЙН ДЭРГЭДЭХ ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ЁС ЗҮЙН САЛБАР ХОРООНЫ 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

| № | Үйл ажиллагаа | Хугацаа /Улирал/ | | | | Хариуцах эзэн | Хамтрагч байгууллага, нэгж | Үр дүн | Хэрэгжилт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | I | II | III | IV | | | | |
| **I. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, холбогдох дүрэм, журмын хэрэгжилтийг ханган ажиллах** | | | | | | | | | |
| 1.1 | Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ 2019.09.04 406 тоот тушаалыг нийт ажилтан, суралцагч нар, үйлчлүүлэгчид таниулан сурталчлах | + | + | + | + | ЁЗСХ | УНТЭ Захиргаа, хүний нөөцийн алба | Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм мэдээллийн самбарт байршуулах, нэгжүүдэд тараах материал, гарын авлагаар таниулан сурталчилж мэдлэг эзэмшүүлсэн байна. | 1. Төрийн албан хаагчийн ёсзүйн тухай хууль, Эмнэлгийн мэргэжилтэний ёсзүйн дүрэм, холбогдох журмуудыг Улсын нэгдүгээр төв эмнэлгийн гадаад сайт – Ил тод булан – Ёсзүйн салбар хороо цэсэнд холбогдох байршуулан ажиллаж байна. http://unte.moh.gov.mn/<br><br>Зураг. УНТЭ гадаад сайт – ил тод булан – Ёсзүйн хороо цэс<br>2. Мөн Ёсзүйн салбар хорооны 120*180 хэмжээтэй, санал хүсэлтийн хайрцагтай 2 мэдээллийн самбарны<br>✓ Ёсзүйн үйл ажиллагаа<br>✓ Авлигын эсрэг үйл ажиллагаа<br>✓ Хууль эрхзүй<br>✓ Зөвлөмж<br>✓ Сургалт |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | ✓ Мэдээлэл<br>✓ Зарлал буланд тухай бүрт мэдээ, мэдээллийг байршуулан ажилтан болон үйлчлүүлэгчийг мэдээллэр хангах нөхцлийг бүрдүүлэн, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг гүйцэтгэж байна.<br><br><br>Зураг. Өргөтгөлийн байрны 1-р давхарт байршуулсан самбар<br><br>3. Байгууллагын нийт ажилтнуудад албаны all@fchm.edu.mn цахим шуудангаар 2026.01.16-ны өдөр<br>- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ<br>- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, хариуцлага сэдэвт үндэсний хэлэлцүүлгээс гаргасан уриалга, зөвлөмжийг хүргүүлж, “Ёс зүйн зөрчлийг үл тэвчих сэтгэлгээг хэвшүүлэх-Эерэг, эрүүл ажилтан-Хариуцлагатай байгууллага-Итгэлтэй үйлчилгээг хамтдаа төлөвшүүлэх” уриалгыг хүргүүлэн хамтарч ажиллаж байна. |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | <br><br>Зураг. Албаны цахим шуудан хүргүүлсэн байдал |
| 1.2 | Эмнэлгийн мэргэжилтний Ёс зүйн салбар хорооны гишүүдийг сонгон шалгаруулах асуудлыг удирдлагад танилцуулах, хамтран оролцох | + | | | | ЁСЗХ | УНТЭ Захиргаа, хүний нөөцийн алба | Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны бүрэлдэхүүн шинээр томилогдсон байна. | УНТЭ-ийн ерөнхий захирлын 2026.03.12-ны өдрийн А/138 тушаалаар УНТЭ-ийн дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний ёс зүй салбар хорооны дарга, орлогч дарга, гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дуусаж байгаатай холбогдуулан тус хорооны гишүүний нээлттэй сонгон шалгаруулалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан.<br>Сонгон шалгаруулалтын зарыг 2026.03.03-2026.03.31, 2026.04.06-2026.04.17-ны өдрийг дуустал хугацаанд нээлттэй, ил тод зарлан мэдээлж сонгон шалгаруулалтыг хууль, журмын дагуу зохион байгуулсан. Сонгон шалгаруулалтын үнэлгээний дүн, шалгарсан нэр дэвшигчдийн мэдээллийг Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороонд УНТЭ-ээс 2026.06.08-ны өдрийн 1/1172 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.3 | Ёсзүйн болон анагаах ухааны эрхзүй, үйлчилгээний стандартын мэдлэг олгох гарын авлага, тараах материалыг хэвлүүлэх, шаардлагатай нэгжүүдэд таниулан байршуулах | + | + | + | + | ЁЗСХ | УНТЭ Дотоод хяналтын мэргэжилтэн | Соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх таниулан сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулсан байна | УНТЭ-ийн **15** алба, **12** төв, **16** тасгийн мэдээллийн самбартд “Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгчийн ёсзүйн хэм хэмжээ”-г байршуулж, үйлчлүүлэгчдэд танилцуулж, соён гэгээрүүлэх, мөрдүүлэх ажлыг гүйцэтгэж байна.<br><br><br>Зураг. Үйлчлүүлэгчийн эрх, үүргийг таниулах самбар<br><br>Зураг. Үйлчлүүлэгчийн эрх, үүргийг таниулах самбар |

<table>
<tr>
<td></td>
<td></td>
<td></td>
<td></td>
<td></td>
<td></td>
<td></td>
<td></td>
<td></td>
<td>

Зураг. Үйлчлүүлэгчийн эрх, үүргийг таниулах мэдээллийн самбар</td>
</tr>
<tr>
<td>1.5</td>
<td>Байгууллага доторх мэдээллийн дэлгэц самбаруудыг эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгчийн үүргийг таниулан сурталчлах</td>
<td>+</td>
<td>+</td>
<td>+</td>
<td>+</td>
<td>ЁЗСХ</td>
<td>УНТЭ Мэдээлэл технологийн алба</td>
<td>Соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх таниулан сурталчлах үйл ажиллагаа зохион байгуулсан байна</td>
<td>УНТЭ-т ашиглагдаж буй нийтийн эзэмшлийн талбайд байршилтай мэдээллийн 15 самбар, мэдээллийн 6 дэлгэцээр байгууллагаар үйлчлүүлэгчийн ёсзүйн хэм хэмжээг таниулан сурталчилж байна.<br><br>Нийтийн эзэмшлийн талбайд байрлах тв, дэлгэцүүд - хүснэгтээр
<table>
<tr><th>ТВ, дэлгэц байршил</th><th>Тоо ширхэг</th></tr>
<tr><td>В блок Амбулатори 1-р давхрын өлгүүрийн хэсэгт</td><td>50 инч дэлгэц - 1 ширхэг</td></tr>
<tr><td>В блок Амбулатори 1-р давхрын коридор</td><td>50 инч дэлгэц - 1 ширхэг</td></tr>
<tr><td>А блок хэвтэн эмчлүүлэгчдийн 2-р давхар. Эрүүл мэндийг дэмжих төв сувилагчийн пост</td><td>50 инч дэлгэц - 1 ширхэг</td></tr>
<tr><td>А блок хэвтэн эмчлүүлэгчдийн 2-р давхар. Эрүүл мэндийн даатгалын өвчний түүх нээх хэсэг</td><td>60-120 хэмжээтэй лед дэлгэц - 1 ширхэг</td></tr>
<tr><td>Яаралтай тусламжийн тасаг - Хүлээлгийн хэсэг</td><td>50 инч дэлгэц - 1 ширхэг</td></tr>
<tr><td>Өргөтгөлийн зүүн байр 1-р давхар MRI, CT оношлогооны хэсэг</td><td>50 инч дэлгэц - 1 ширхэг</td></tr>
</table></td>
</tr>
</table>

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | <br>Зураг. Мэдээллийн дэлгэц |
| **II. Эмнэлгийн мэргэжилтнүүдийн харилцаа хандлагыг дээшлүүлэх чиглэлээр сургалт, судалгаа явуулах, ажил зохион байгуулах** | | | | | | | | |
| 2.1 | Ёс зүйн болон анагаах ухааны эрхзүй, үйлчилгээний стандартыг хэрэгжүүлэх сургалтуудыг үе шаттай зохион байгуулах | + | + | + | + | ЁЗСХ | УНТЭ-ийн ҮЭ-ийн хороо Сургагч багш нар | Байгууллагын соёл сайжирсан байна. Үйлчилгээний стандартыг нэвтрүүлж хэрэгжүүлсэн байна. Ажилтны сэтгэл ханамж нэмэгдсэн байна. Ёсзүйн хэм хэмжээтэй холбогдох гомдол буурсан байна | 1. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, хариуцлага сэдэвт үндэсний хэлэлцүүлгээс гаргасан уриалга, зөвлөмжийг хүргүүлж, “Ёс зүйн зөрчлийг үл тэвчих сэтгэлгээг хэвшүүлэх-Эерэг, эрүүл ажилтан-Хариуцлагатай байгууллага-Итгэлтэй үйлчилгээг хамтдаа төлөвшүүлэх” уриалгыг хүргүүлэн хамтарч ажиллаж байна.<br>2. Мөн MNS 7068:2025 Төрийн албаны үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага стандартыг нийт ажилтнуудад 2026.06.25-ны өдөр танилцуулан, албаны цахим шуудангаар хүргүүлсэн. |
| 2.2 | Ёс зүйн хорооны гишүүдийг чадавхижуулах сургалтад хамрагдах | + | + | + | + | ЁЗСХ | ЁЗСХ-ны дарга, нарийн бичгийн дарга | ЁЗСХ-ны гишүүдийн мэдлэг, ур чадвар чадавхи сайжирсан байна. | Гишүүдийг чадавхижуулах саналыг ЭМЯ-ны дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороонд хүргүүлсэн. |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.3 | Ёс зүйн сургагч багш нарыг бэлтгэх | + | + | + | + | ЁЗСХ сургалтын баг | ЭМЯ, ЭМХТ, АШУҮИС, бусад ТББ | Тасаг, нэгж бүрт 1 сургагч багш бэлтгэгдсэн байна. | Төрийн албаны Ёс зүйн зөвлөлөөс сургагч багш бэлтгэх хөтөлбөрийг эхлүүлсэн бөгөөд сургагч багш бэлтгэх хөтөлбөрт хамрагдах санал, хүсэлтийг хүргүүлэн ажиллаж байна. |
| 2.4 | Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгчид зориулсан сургалтыг НЭМА болон нэгжүүдтэй хамтран зохион байгуулах | + | + | + | + | ЁЗСХ сургалтын баг | УНТЭ, НЭМА, нэгжүүд | Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэх үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж нэмэгдсэн байна | 2026 оны эхний хагас жилд 10 видео мэдээлэл, 101 зурагт мэдээллийг боловсруулан байршуулж, байгууллагын үйл ажиллагаа, тусламж үйлчилгээний талаарх мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлсэн. Тайлант хугацааны сүүлийн 90 хоногийн байдлаар байгууллагын цахим хуудсанд нийт 1,081,701 удаагийн хандалт бүртгэгдсэн.<br><br>https://www.facebook.com/profile.php?id=61553436448298 линкээр орж үзнэ үү.<br><br><br>Зураг. Хандалтын тоо<br><br>Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэг нь иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэг, зөв дадлыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор ТВ5 телевизийн "Гэгээн эрүүл мэнд" **подкасттай хамтран нийт** 6 эмчийг оролцуулан |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.5 | | | | | | | | | эрүүл мэндийн боловсрол олгох цуврал нэвтрүүлгийг зохион байгуулан хамтран ажилласан.   Зураг. Хандалтын тоо |
| 2.5 | Байгууллагын соёл, үйлчилгээтэй холбоотой сэтгэл ханамжийн судалгааг авах, тайлагнах | + | + | + | + | ЁЗСХ судалгаа хариуцсан баг | УНТЭ Дотоод хяналтын мэргэжилтэн | Судалгааны үр дүнг эмнэлгийн удирдлага, дотоод хяналтын мэргэжилтэнд тайлагнаж ажилласан байна. | Салбар хороо нь УНТЭ-ийн ЭМТҮ-ний Чанар, аюулгүй байдлын албатай хамтран үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгааг авсан. Судалгааг нэгтгэн удирдлагад танилцуулсан. |
| **III. Ёс зүйн салбар хорооны өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, бусад** | | | | | | | | | |
| 3.1 | Иргэн, үйлчлүүлэгч, ажилтнаас хороонд ирүүлсэн өргөдөл гомдлыг зохих журмын дагуу хүлээн авч, хэлэлцэн, шийдвэрлэж ажиллах | + | + | + | + | ЁСЗХ | УНТЭ ЭМТҮ-ний Чанар, аюулгүй байдлын алба<br><br>Захиргаа, хүний нөөцийн алба | Хурлын тэмдэглэл, тайлан | 2026 оны эхний хагас жилд УНТЭ-ийн дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороонд 1 үйлчлүүлэгчээс, 1 ажилтнаас гомдол ирсэн. Үйлчлүүлэгчийн гомдлын дагуу өргөдлийг судлан эмч, үйлчлүүлэгч нарыг эвлэрүүлэн зуучилсан. Ажилтны гомдлыг эмнэлгийн захиргаанд шилжүүлсэн. |
| 3.2 | Ёс зүйн салбар хорооны | + | + | + | + | ЁЗСХ | ЁЗСХ, ЗАА- | Байгууллагын гадаад | Салбар хорооны хагас жилийн |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах | | | | | нарийн бичгийн дарга | ны олон нийттэй харилцах мэргэжилтэн | сайтны – ил тод булан – Ёсзүйн хороо дэд цэсэнд төлөвлөгөө, тайланг тухай бүрт мэдээллэж ажилласан байна | төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг эмнэлгийн гадаад сайтны – ил тод байдал – салбар хороо буланд оруулсан. |
| 3.3 | Ёс зүйн салбар хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэн хэлэлцэх | | + | | + | ЁЗСХ дарга, нарийн бичгийн дарга | | Үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 2 удаа хэлэлцэгдсэн байна. | Салбар хорооны 2026 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг гишүүдэд цахимаар хүргүүлж танилцуулсан. |
| 3.4 | Ёс зүйн салбар хорооны самбарыг тухай бүрт мэдээллээр баяжуулах | + | + | + | + | ЁЗСХ нарийн бичгийн дарга | ЁЗСХ, ЭБАТ | Ил тод байдал хангагдсан байна | Төв, тасаг, нэгжийн болон ёс зүйн мэдээллийн самбарыг сар тутамд мэдээ, мэдээллээр баяжуулан ажиллаж байна. |
| 3.5 | Ёс зүйн салбар хорооны гишүүдийн цалин, урамшууллыг ажлын үр дүнд тулгуурлан олгох | + | + | + | + | ЁЗСХ хорооны дарга | УНТЭ Захиргаа | ЁЗСХ-ны үйл ажиллагаа тогтворжиж, гишүүдийн идэвх нэмэгдэнэ | Төсвийн хэмнэлтийн тухай хууль, журамтай холбогдуулан УНТЭ-ийн дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны гишүүдэд 2026 онд урамшуулал цалин олгогдоогүй болно. |
| 3.6 | Ёс зүйн салбар хорооны албан бичиг хэргийн хөтлөлт, хурлын тэмдэглэл болон өргөдөл гомдлын бүртгэл, шийдвэрлэлтийг хяналт тавин хэрэгжүүлж ажиллах | + | + | + | + | ЁЗСХ нарийн бичгийн дарга | ЁЗСХ | Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, бичиг баримтын бүрдэлт эмх цэгц хангагдана | Салбар хорооны нарийн бичгийн дарга нь хууль, журмын дагуу баримт бичгийг хөтлөн явуулж байна. |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.7 | Мэргэжлийн зэргийн шалгалтанд орох эмнэлгийн мэргэжилтэнд хорооноос тодорхойлолт бичиг гаргаж өгөх эсэх асуудлыг шийдвэрлэн ажиллах | + | + | + | + | ЁЗСХ дарга, нарийн бичгийн дарга | ЁЗСХ | Ажилчдын хүсэлтийн дагуу тодорхойлолтыг цаг хугацаанд нь гаргаж өгөх | Салбар хороо нь 2026 оны эхний хагас жилд мэргэжлийн нийгэмлэг, холбоодод нийт 35 тодорхойлолтыг хүргүүлж ажилласан. |
| 3.8 | ЁЗСХ-ны бүрэлдэхүүн бусад ЁЗСХ-ны үйл ажиллагаа, ажилтай танилцах, харилцан туршлага солилцох, Мөн Ёсзүйн хяналтын хорооны бүрэлдэхүүнтэй уулзаж зөвлөгөө, мэдээлэл авах | | + | | + | ЁЗСХ-ны бүрэлдэхүүн | ЁЗСХ | Сайн ажиллаж байгаа ЁЗСХ-ны сайн туршлагыг нэвтрүүлэх | Ёс зүйн салбар хороодоос туршлага судлах саналыг ЭМЯ-ны дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороонд уламжилсан болно. |
| 3.9 | Ёс зүйн салбар хорооны үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллахад шаардлагатай бичиг хэргийн зардал | + | + | + | + | ЁЗСХ дарга, нарийн бичгийн дарга | ЁЗСХ | Ёсзүйн салбар хорооны хэвийн үйл ажиллагаа хангагдана. | Бичгийн цаас болон эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны A4, A5 хэмжээтэй албан бланкийг УНТЭ-ийн Захиргаанд хүсэлт гарган, хэвлүүлэн, хүлээн авч ажиллаж байна. |

Хянасан: УНТЭ-ийн дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтэний ёс зүйн салбар хорооны дарга, Ерөнхий мэс заслын тасгийн их эмч Б.Ганзориг

Боловсруулсан: УНТЭ-ийн дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны нарийн бичгийн дарга, Захиргаа, хүний нөөцийн албаны хүний нөөцийн менежер О.Лхагвасүрэн